



## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2017 оны 03 сарын 17 өдөр

Дугаар А/1144

Улаанбаатар хот

### Тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засгийн газрын 2009 оны 05 дугаар, 2014 оны 34 дүгээр, 2016 оны 124 дүгээр тогтоол, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 5/10 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүрийн 05 дугаар сарын 3 дахь долоо хоногийн Бямба гарагийг бүх нийтээр биеийн тамир, спортыг дэмжих автомашингүй өдөр болгож, “Улаанбаатар марафон” олон улсын гүйлтийн тэмцээн зохион байгуулсугай.

2. “Улаанбаатар марафон” олон улсын гүйлтийн тэмцээнийг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг хавсралт ёсоор байгуулсугай.

3. Энэ захирамжийн 1 дүгээр зүйлд заасан олон улсын гүйлтийн тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг тооцож, нийслэлийн 2017 оны төсөвт тусгасан “Зүүн хойд Азийн бизнес, аялал жуулчлал, соёл, санхүүгийн төв болох арга хэмжээний зардал”-аас гаргахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс /Э.Ганхүү/-т зөвшөөрсүгэй.

4. “Улаанбаатар марафон” олон улсын гүйлтийн тэмцээнд нийслэл, дүүргүүдийн төр, захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, их, дээд сургууль, коллеж болон ерөнхий боловсролын сургууль, иргэдийг өргөнөөр хамруулахыг Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо /Ж.Ганболд/-нд болон дүүргүүдийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Энэ захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, явц, үр дүнг тухай бүр танилцуулж байхыг нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч Ш.Анхмаад, уг арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сурталчлахыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс /Э.Дагиймаа/-т тус тус үүрэг болгосугай.


НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН  
ЗАХИРАГЧ



С.БАТБОЛД

111020000743

Нийслэлийн Засаг даргын 2017 оны  
03 дугаар сарын 17-ны өдрийн  
..... захирамжийн хавсралт



### АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- Ахлагч -Нийслэлийн нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч-Нийслэлийн Засаг даргын орлогч
- Дэд ахлагч Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын дэд сайд /зөвшилцсөнөөр/
- Гишүүд:
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга;
  - Улаанбаатар хотын Ерөнхий менежер бөгөөд Захирагчийн ажлын албаны дарга;
  - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Биеийн тамир, спортын бодлогын газрын дарга /зөвшилцсөнөөр/;
  - Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /зөвшилцсөнөөр/;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсийн дарга;
  - Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын дарга;
  - Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дарга;
  - Нийслэлийн Боловсролын газрын дарга;
  - Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны дарга;
  - Нийслэлийн Залуучуудын хөгжлийн газрын дарга;
  - Нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга;



- Нийслэлийн Соёл, урлагийн газрын дарга;
- Нийслэлийн Тээврийн газрын дарга;
- Улаанбаатар хотын Цагдаагийн газрын дарга;
- Багануур дүүргийн Засаг дарга;
- Багахангай дүүргийн Засаг дарга;
- Баянгол дүүргийн Засаг дарга;
- Баянзүрх дүүргийн Засаг дарга;
- Сонгинохайрхан дүүргийн Засаг дарга;
- Сүхбаатар дүүргийн Засаг дарга;
- Хан-Уул дүүргийн Засаг дарга;
- Чингэлтэй дүүргийн Засаг дарга;
- Налайх дүүргийн Засаг дарга;
- Улаанбаатар хотын Цагдаагийн газрын Замын цагдаагийн албаны дарга бөгөөд Нийслэлийн хөдөлгөөний хяналтын газрын дарга;
- “Монгол наадам цогцолбор” ОНӨТҮГ-ын дарга;
- “Хот тохижилтын газар” ОНӨААТҮГ-ын дарга;
- Соёлын төв өргөөний захирал;
- “Гэрэлтүүлэг чимэглэл” ХХК-ийн гүйцэтгэх захирал;
- Монголын үндэсний олимпийн хорооны дэд ерөнхийлөгч /тохиролцсоноор/;
- Монголын хэт холын зайн гүйлтийн холбооны ерөнхий нарийн бичгийн дарга /тохиролцсоноор/;
- Монголын оюутны холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/;
- Монголын оюутны спортын холбооны ерөнхийлөгч /тохиролцсоноор/.
- Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны Нийтийн биеийн тамирын хөгжлийн хэлтсийн дарга.

Нарийн  
бичгийн дарга